



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2016 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, 5.1.4 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, 6.1.3 дахь заалт, 6.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх 2016 оны ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү төлөвлөгөөнд суурилан байгууллагын онцлогт тохируулан нарийвчилсан төлөвлөгөө батлан ажиллахыг боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, биелэлтэд хяналт тавьж, тайланг энэ оны 11 дугаар сарын 05-ний өдрийн дотор танилцуулж холбогдох байгууллагад хүргүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /Л.Цэдэвсүрэн/-т даалгасугай.



Л.ГАНТӨМӨР

tushaal.s.dok.07

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ 2016 ОНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**



№	Хэрэгжүүлэх арга ХЭМЖЭЭ	№	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		Хариуцах нэгж, мэргэжилтний нэр	Төсөв (мян. төг.)	Хүрэх үр дүн
			Арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа			

Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа

Нэг. Авлигаас урьдчилан сэргийлэх; шударга ёсыг тогтоох

1	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны "Авлига, ашиг сонирхлын зөрчилөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх 2016 оны ажлын төлөвлөгөө"-г батлуулан хэрэгжилтийг ханган ажиллана.	1.	Төлөвлөгөөг Сайдын тушаалаар батлуулж хэрэгжилтийг ханган арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	II- XII	ТЗУГ Л. Цэдэвсүрэн П.Нямхүү	-	Төлөвлөгөө чанартай, үр дүнтэй, хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж тодорхой үр дүнтэй үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэн ил тод байдлыг хангаж ажилласан байна.
			Харьяа байгууллагуудын дарга, захирлын өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд нийцүүлэн төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байх.		Харьяа байгууллагуудын дарга, захирал		Харьяа байгууллагуудын төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтэнд хяналт тавьж заасан хугацаанд тайланг ирүүлсэн байна.
2	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын томилогдог дарга, захирал нар болон Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай 2016 онд байгуулах үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээнд	2.	Аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээнд Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах тодорхой заалтыг тусгасан байна.	II	БХЗГ Д.Эрдэнэчимэг	-	Аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээнд тодорхой заалтуудыг тусгаж Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар хийсэн ажлын хэрэгжилтийг дүгнэсэн байна.

<p>холбогдох хуулийг хэрэгжүүлэх тодорхой зүйл заалтыг тусгаж ажиглана.</p>	<p>Харьяа байгууллагын Захирал, дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээнд Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах тодорхой заалтыг тусгасан байна.</p>	<p>БХЗГ Д.Эрдэнэчимэг ШУБЭГ Ж.Даваасамбуу СБЗГ Д.Гантөмөр</p>	<p>Аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээнд тодорхой заалтуудыг тусгаж Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар хийсэн ажлын хэрэгжилтийг дүгнэсэн байна.</p>
<p>3 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх холбоотой үйл ажиллагааг яам болон харьяа байгууллагуудад холбогдох төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллана.</p>	<p>4. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх чиглэлд яам болон харьяа байгууллагуудад авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах.</p>	<p>ТЗУГ Л.Цэдэвсүрэн П.Нямхүү Харьяа байгууллагуудын захирагч, дарга нар</p>	<p>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх зорилгоор холбогдох төрийн бус байгууллагуудтай хамтран тодорхой үйл ажиллагаануудыг зохион байгуулан ажиглаж үр дүнг үнэлсэн байна.</p>

Байгууллагын ил байдлыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Хоёр. Эрх зүйн орчин

<p>4 Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын Хуралдаанаар хэлэлцүүлэх хууль, тогтоолын төсөл мөн Сайдын Батлах дүрэм, журмын төсөлд иргэд, холбогдох төрийн бус байгууллагийн санал бодол оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажиллана.</p>	<p>5. Хэлэлцүүлэх хууль, тогтоол, Сайдын дүрэм, журмын төслүүдэд иргэд болон бусад сонирхогч этгээдүүдээс санал, дүгнэлт авах боломжийг цахим хуудасанд байршуулах, холбогдох мэргэжлийн байгууллагуудаар хэлэлцүүлэх боломжийг бүрдүүлэх боломжийг хангах.</p>	<p>II-XI Холбогдох газар, хэлтсийн дарга, хэвлэл мэдээллийн ажиглан</p>	<p>Монгол Улсын Их Хурал, Засгийн газраар батлуулах Хууль болон дүрэм, журмын төслийг иргэд болон олон нийтийн байгуулагаар хэлэлцүүлж хууль зүйн үндэслэлтэй санал дүгнэлтийг тусгаж, яамны цахим сайтад байршуулж сонирхогч этгээдүүдийг саналт дүгнэлт судалган үзэж хууль зүйн үндэслэлтэй санал, дүгнэлтийг төсөлд тусгасан байна.</p>
<p>5 Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас олгож буй тусгай зөвшөөрөл, эрх олгох, зөвшөөрөл олгохтой холбоотой мэдээ, мэдээлэлийг олон нийтэд ил тод нээлттэй түргэн шуурхай олгох, танилцах арга хэмжээг авч ажиллана.</p>	<p>6. Тусгай зөвшөөрөл, эрх, зөвшөөрөл олгох болон түүнтэй холбогдолтой мэдээ, мэдээлэл болон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын нэр, хаяг, үйл ажиллагааны чиглэл зэргийг цахим хуудсанд байршуулах.</p>	<p>II-XI Холбогдох газар, хэлтсийн дотоод ажил хариуцсан мэргэжилтнүүд СБТГ Г.Чинзориг</p>	<p>Яамнаас олгож байгаа тусгай зөвшөөрөл, эрх олгох, зөвшөөрөлүүдийн мэдээ, мэдээлэл болон тэдгээртэй холбоотой бүрэн, цогц мэдээллийг цахим хуудсанд байршуулсан байна.</p>
<p>6 Иргэд, байгууллагаас ирүүлсэн авлага, ашиг</p>	<p>7. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны эрхлэх асуудлын хүрээнд</p>	<p>ТЗУГ Г.Амаржаргал</p>	<p>Иргэд, байгууллагаас ирүүлсэн авлига, ашиг сонирхлын</p>

<p>сонирхлын зөрчилтэй холбоотой болон бусад төрлийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч түргэн шуурхай шийдвэрлэх, шийдвэрлэлтийн мэдээллийг цахим хуудсан байршуулах арга хэмжээ авч ажиллана.</p>	<p>иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийг түргэн шуурхай хариу өгөх боломжыг бүрдүүлнэ. Мөн тус яамны асуудал хариуцсан албан хаагчдийн шаардлагатай мэдээллийг яамны цахим хуудсанд байршуулна.</p>	<p>II-XI СБТГ Г.Чинзориг</p>	<p>зөрчилтэй холбоотой болон бусад төрлийн өргөдөл, гомдол, хүсэлтийг шийдвэрлэсэн талаарх тоон болон графикт мэдээллийг сар бүр мэдээлэн холбогдох өөрчлөлтийг тухай бүр нь хийсэн байна.</p>
<p>7 Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ хүрээнд гаргаж ирүүлсэн шийдвэрийг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх арга хэмжээг авч ажиллана.</p>	<p>8. Авлигатай тэмцэх газраас хууль тогтоомжид ницүүлэн ирүүлсэн зөвлөмж, зохион байгуулах арга хэмжээ, зөрчил арилгуулах болон хариуцлага тооцох, арга хэмжээ авхуулсан ирүүлсэн албан бичгүүдийн хүлээн авч шийдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>	<p>II-XI Ш.Булга-Эрдэнэ Холбогдох газар, хэлтсийн дарга нар ТЗУГ П.Нямхүү</p>	<p>Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийн хүрээнд ирүүлсэн зөвлөмж, зохион байгуулах арга хэмжээ, зөрчил арилгуулах болон хариуцлага тооцох, арга хэмжээ авхуулсан ирүүлсэн албан бичгүүдийн хууль тогтоомжид хүрээнд шийдвэрлэж биелэлтийг хургуулсан байна.</p>
<p>Гурав. Хүний нөөц</p>			
<p>8 Болговсрол, соёл, шинжлэх ухааны яамны шаардлагатай албан хаагчдын ажлын байрыг сэлгэн ажиллуулах, хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцаж мэдээлэл авах боломж нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээг авч ажиллана.</p>	<p>9. Яам болон Сайдын бүрэн эрхийн хүрээнд томилогддог ажлын байрны сул орон тооны мэдээ, мэдээлэл, сонгон шалгаруулалтын зар түүнтэй холбогдолтой нууцад хамаарахаас бусад мэдээлэл, сонгон шалгаруулах журамтай холбоотой мэдээллийг цахим хуудсанд байршуулна.</p>	<p>II-XI Ш.Булга-Эрдэнэ ТЗУГ Л.Цэдэвсүрэн Ш.Сарантуяа СБТГ Г.Чинзориг</p>	<p>Сул орон тоо, тэдгээрийн сонгон шалгаруулалтын мэдээллийг цахим хуудсанд байршуулж хүссэн иргэд чөлөөтэй өрсөлдөх боломжыг бүрдүүлж мэдээллийг тухайн бүр нь цахим хуудсанд тусгана. Зарим ажлын байрны тодорхойлолтын өөрчилж шаардлагатай албан хаагчдыг сэлгэн ажилуулсан байна.</p>
<p>9 Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга үнэлэх, хандах хандлага, үр нөлөөг дээшлүүлэн ажиллана.</p>	<p>10. Давхар ажил эрхлэлтийн судалгаа, авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаалын судалгааг гаргах.</p> <p>11. Албан хаагчдын ажил үүргийг ил тодоор үнэлэх дүгнэх ажлыг зохион байгуулж шийдвэрлэнэ.</p>	<p>II-XI Ш.Булга-Эрдэнэ ТЗУГ Л.Цэдэвсүрэн Ш.Сарантуяа</p>	<p>Давхар ажил эрхлэлтийн судалгаа, авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаалын судалгааг гаргаж холбогдох арга хэмжээг авсан байна.</p> <p>Удирдлагаас мэргэжилтэнүүдийн ажлыг гүйцэтгэлийг шударга үнэлсэн байна.</p>
<p>10 Яамны удирдлагаас гаргасан нууцад хамаарахаас бусад шийдвэрийг ил тод нээлттэй байдлыг хангах арга хэмжээг авч ажиллана.</p>	<p>12. Яамны удирдлагаас нууцад хамаарахаас бусад шийдвэрийг ил тод нээлттэй байдлыг ханган яамны алба хаагчдад мэдээлж цахим хуудсанд байршуулна.</p>	<p>II-XI СБТГ Г.Чинзориг</p>	<p>Яамны удирдлагаас нууцад хамаарахаас бусад гаргаж буй шийдвэрийн ил тод нээлттэй байдлыг ханган яамны алба хаагчдад мэдээлэх болон цахим хуудсанд байршуулсан байна.</p>

Дөрөв. Санхүү, эдийн засаг

11	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны төвсийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хувиарлалт, худалдан авах ажиллагаа, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Худалдан авах ажиллагааны талаарх шаардлагатай арга хэмжээг зохион байгуулан ажиллана.	Төсвийн орлог, зарлага, гадаадын зээл, тусламж, түүний хувиарлалт, худалдан авах ажиллагааг Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын тогтоолын дагуу цахим хуудсанд байршуулна. Тус яамны тухайн жилийн төсөв, өмнөх жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, дараа жилийн төсвийн төсөл зэргийг цахим хуудсанд зохих журмын дагуу байршуулна.	II-XI	<p align="center">СЭЗГ Ц.Баярхүү Б.Дэнсмаа СБТГ Г.Чинзориг</p>	Шилэн дансны тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу яамны цахим хуудсан төсөв, санхүү, аудитын тайлантай холбоотой мэдээ, мэдээллийг бүрэн байршуулаж ажилласан байна.
----	---	---	-------	--	---

Хяналт, шинжилгээ, үнэлгээ

Тав. Авлигын эсрэг хууль тогтоомж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах

12	Дотоод аудитын хяналт шалгалтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, хяналтын талаарх мэдээ, мэдээллийн яамны цахим хуудсанд байршуулах арга хэмжээг авч ажиллана.	14. Дам болон харьяа байгууллагад төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлж хийх.	15. Дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчлийг холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх.	II-XI	<p align="center">ХШУДАХ М.Оюунцэцэг</p>	Төлөвлөгөөнд тусгагдсан хяналт шалгалтыг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, хийсэн хяналт шалгалтын дүнг, өгсөн зөвлөгөө зөвлөмж, авах арга хэмжээ түүний талаар мэдээ, мэдээллийг яамны цахим хуудсанд байршуулсан байна.
----	--	---	--	-------	---	--

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ